

ЭРДЭНЭЦАГААН СУМ 2021.01.25.

2021 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

Удирдлага зохион байгуулалт, хууль эрх зүйн хүрээнд:

Сумын 2020 оны жилийн эцсийн тайланг аймгийн ХШҮ,ДА-ын хэлтсээс өгсөн удирдамж, чиглэл зааврын дагуу 18 үзүүлэлтээр гаргаж, АСЗД-ын гэрээний хавсралт 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ЗГХЭГ-ын даргын 100 дугаар тогтоолын хавсралтын дагуу гаргаж хүргүүлээ.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Шалгуур үзүүлэлтийг боловсруулан аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж хянууллаа.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан бүлэг сумын үйл ажиллагаатай танилцаж үүрэг чиглэл өгч ажиллаа.

Сумын ЗДТГ-ын мэргэжилтэнүүд, БЗД, төсөвт байгууллагуудад Аймаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2021 оны хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтуудыг хүргэж 2021 оны төлөвлөгөө, тайлан гаргах чиглэл өгч ажиллаж байна.

Сумын ЗДТГ-ын эд хөрөнгийн тооллогыг хийж гүйцэтгэлээ. Халдварт Коронавирээс урьдчилан сэргийлэх ажлын эрч хүчийг алдахгүй байж хүн ардыг урьдчилан сэргийлэх, сонор сэрэмжийг дээшлүүлэх зорилгоор УОК, АОК, Аймгийн засаг даргын шийдвэр чиглэлийг удирдлага болгон 2021 оны 1 дүгээр сард Хяналт шалгалт хийх А/02, А/09, Иргэдийг татан авах, тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах А/14 захирамжуудыг тус тус гаргаж хэрэгжүүлж ажиллаж байна.

Санхүү албаны хүрээнд:

2020 оны дансны үлдэгдлийг хааж татан төвлөрүүлэлт гүйлгээ хийж гүйцэтгэсэн.

/мян.төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Олгосон санхүүжилт	Татан төвлөрүүлэлт	Гарсан зардал
1	ИТХурал	107226.9	3627.7	103599.2
2	ЗДТГазар	685559.9	123214.7	562345.2
3	СТөв	123590.1	6952.9	116637.2
4	ЕБСургууль	1405738.8	130239.2	1275499.6
5	1-р цэцэрлэг	393486.7	16684.7	376802.0
6	2-р цэцэрлэг	279005.3	13237.1	265768.2
7	ЭМТөв	406728.3	1927.1	404801.2
		3401336.0	295883.4	3105452.6

2020 санхүүжилтийг байгууллагын нягтлан бодогч нартай тулган баталгаажуулан ажилласан. 2020 оны ЗДТГ-ын эд хөрөнгийн тооллогыг ажлын хэсгийг ахлан эд хөрөнгийн хариуцлагыг сайжируулах ажлын хүрээнд тооллыг журам, гэрээ, баталгааны хуудасыг санаачлан боловсруулж тушаал гаргуулан мөрдөж ажиллан албан хаагчдад танилцуулан эд хөрөнгө хариуцагчийн гэрээ болон бүртгэл баталгааны хуудсаар баталгаажуулан 2 хувь үйлдэж, тооллогоор Засаг даргын тамгын газрын 30 албан хаагчийн 124 нэр төрлийн 1399 эд хөрөнгийг нэг бүрчлэн нүд үзэж тоолж тооллогын илтгэх хуудасыг удирдлагад хүргүүлэн ажилласан.

2020 оны тайлан тушаалттай холбогдуулан аудитын газраас ирсэн албан тоотыг байгууллагын дарга нягтлан бодогч нярав нартай хурал хийж аудитын байгууллагад тайлан тушаах хувиар гарган Засаг даргаар баталгаажуулан танилцуулан ажилласан.

2021 оны төсвийн хуваарыг нягтлан бодогч нартай хийж баталгаажуулан, 2020 оны ААНБ-ын сангийн яамны тайлан тушаах ажлыг зохион байгуулан жагсаалт гарган мэдээлэл хүргүүлэн ажилласан.

Архив, бичиг хэргийн хүрээнд:

2021 оны 01 дүгээр сард Сумын Засаг даргын А захирамж -7, Б захирамж-0, Тамгын газрын даргын Б/Тушаал-2, А тушаал.1, Засаг даргын болон тамгын газрын дарга албан тоот -20, Өргөдөл, хүсэлт -5-ыг тус тус бүртгэн гаргаж ажиллаа. Мөн 2020 онд үйлдсэн албан бичиг, захирамж, тушаалд дотоод товъёог үйлдсэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэгт Захирамж тушаалын стандарт эрхзүйн үндэслэлийг шалгуулж ажилласан.

2021 оны 01 дүгээр сарын 10-ын өдөр Архивт хадгалагдаж буй нийт баримтын тоон мэдээг стандартын дагуу хүснэгтлэн Аймгийн төрийн Архивт цахимаар явуулж ажиллаа.

Нийгмийн даатгал: 2020 оны мэдээ тайлангийн ажлыг 01-р сарын 15-ний дотор хугацаанд нь хийж ажиллаа.

2021 онд Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийг сумын иргэд, даатгуулагчдад сурталчилах ажлыг зохион байгуулах зорилгоор ЭРДЭНЭЦАГААН НИЙГМИЙН ДААТГАЛ файсбүүк групп нээж 200 орчим иргэдэд мэдээлэл хийж, төсөвт байгууллагын нягтлан бодогч 9, ААН-н дарга эрхлэгч, ня-бо 35 нартай холбогдон Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаар цахим мэдээлэл хүргэсэн.

Хилийн 0146-р ангийн 28 албан хаагчдад Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаар мэдээлэл сурталчилгааг хийж 11 даатгуулагчыг гар утасны АПП-д хамруулсан. СДД-д 108 даатгуулагч 2021 оны гэрээг шинэчилж 8000.0 мянган төгрөг, ЭМД-д 34 иргэний 1862.0 мянган төгрөг төвлөрүүлсэн. Тайлант сард тэтгэвэр, тэтгэмж, ажил

олгогчын шимтгэл СДД, ЭМД, Архивын лавлагаа, утасны зөвөлгөө, бусад гэсэн төрлөөр нийт 516 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

ХАА-н тасаг: 2020 оны жилийн эцсийн тооллогоор мал 5-н төрөл дээрээ өсөж нийт 398 889 толгой малтай болж, тэмээ 734, адуу 47 457, үхэр-29915, хонь 155 835, ямаа 164 948 толгойд хүрсэн байна.

Аймгийн Статистикийн хэлтэс, ХААГазарт долоо хоног бүрийн 3 дахь төлмал, том малын хорогдол өвөлжилтийн мэдээ, Хүн амын хүнсний 8 нэр төрлийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 7 хоног бүр 19 н ААНэгж, дэлгүүрүүдээс авч аймгийн ХАА-н газарт, Онцгой байдал зарласан цагаас хойш 1 дүгээр сарын 13 наас эхлэн өдөр бүрийн 15 цагт хүн амын хүнсний нөөц хангамжийн судалгааг гарган тус тус хүргүүлж ажиллаж байна. Өвс тэжээлийн нөөцийг задалж өвс тэжээлийн хомсдолд орсон өрхүүдийн судалгааг багийн засаг дарга нараар гаргуулж, зах зээлийн үнээс хямдруулж 1 боодол өвсийг 3500 төгрөгөөр борлуулсан.

Мал эмнэлгийн тасаг: 2021 онд хийх гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын захиалгыг ААН тус бүрээс авч МЭГ-т хүргүүлэн ажиллаа.

МЭЭГ-ын даргын 2020 оны 12сарын 31-ны 1/1470 албан тоот, МЭГ-ын даргын 2021 оны 1 сарын 4-ны өдрийн 1/01 албан тоотуудын дагуу 2020 оны Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлтийг 2020 оноос бууруулахгүй тархалтын судалгаанд үндэслэн Сумын ИТХ-аар төлөвлөөгөөг батлуулахаар , Малын Эрүүл мэндийн дэд хөтөлбөрийг боловсруулан төлөвлөөд байна.

Хүнс худалдаа үйлчилгээ: 11-н ААН байгууллагад Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан гарын үсэг зуруулж баталгаажуулсан. Сум хөгжүүлэх сангаас зээлтэй иргэдтэй уулзаж 2020 оны зээлийн үлдэгдлын баталгаа хийлгэж авсан. 2020 оны малчдаас Арьс ширний 478 ширхэг падаан хураан авч программд шивж оруулан Аймгийн ХХААГ-т хүргүүлсэн.

ААНБ-дад QR код хэвлэж тараан хэрэгжүүлж ажиллах талаар заавар зөвлөмж өгч гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр: Хүн амд урьдчилан сэргийлэх болон идэвхитэй хяналтын үзлэгийг эмч нарын үзлэгийн хуваарийн дагуу нийт 291 өвчний учир амбулатор- 160 хүнд үзлэг хийснээс, 36 урьдчилан сэргийлэх үзлэгт , идэвхитэй хяналтаар 52 , гэрийн идэвхитэй үзлэг- 30 гэрийн дуудлага- 13 стационараар 16 нийт хүнийг хэвтүүлэн эмчлүүлээд байна.

Нас баралт- 3 Үүнээс: эмнэлгийн нас баралт 0, гэрт нас барсан 3. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 0, Эмнэлгээс гарсан үйлчлүүлэгч 16, бүх ор хоног 140 чанарын үзүүлэлтүүдтэй байна.

1-р сарын байдлаар 13 эхийг жирэмсний хяналтанд авч 13 эхийг эхний 3 сартай хяналтанд хамруулснаар жирэмсний эрт хяналтын хувь 100 % байна.

ЕБС: 12-р ангийн давтлагыг 1-р сарын 25-ний өдрөөс эхлүүлэхээр Аймгийн Онцгой Комиссоор шийдвэр гарсантай холбогдуулж сайдын 2020 оны А/17, А/63 дугаар тушаалуудыг баримтлан, давтлага хийх анги танхимын ариутгал халдваргүйжилтийг хийх хуваарь гарган сургуулийн орчинд гаднаас орж, гарч байгаа хөдөлгөөнийг байнга хянах, тэмдэглэл хөтлөх, халуун хэмжих бүртгэл хөтлөх бэлтгэлийг хангаж ажиллаж байна. Мөн ажиглах өрөөг бэлтгэж байна. Нэг ангид 10-аас доош хүүхэд байх, сурагч анги, суудлаа солихгүй байхаар зохицууллаа.

Соёл: Энэ сард байгууллагын цахим хаяганд эрүүл мэнд корона вирусын талаарх зөвлөмжийг 29 удаа, соёл урлаг үйл ажиллагаатай холбоот мэдээ мэдээлэл 17 удаа байршуулан ажиллалаа. Номын сангаар 11 хүн ирж үйлчлүүлж гэрээр 21 ширхэг ном гаргалаа. 2 хүнийг Биет бус өв тээгчээр бүртгэн бүртгэл мэдээллийн сангаа баяжууллаа.

Хүүхдийн 2-р цэцэрлэг: Бүлгийн багш нар цахим хичээлүүдийг бэлтгэж технологийн сандаа баяжилт хийсэн. Үүнд: “Хөдөлгөөн эрүүл мэнд” хичээлээр, “Хэл яриа”, “Хөгжим”, “Туршилт танин мэдэхүй”, “Математик энгийн төсөөлөл” зэрэг сэдүүдээр цахим хичээл бэлтгэж цахим сан бүрдүүлсэн.

Бэлтгэл бүлгийг гар оёдлоор тохижуулах зорилгоор багш ажилчид хамтран Ширээний бүтээлэг 10 ширхэг, Сандлын бүрээс 40 ширхэг, Сургалтын хэрэглэгдэхүүн 25 ширхэг, Үзүүлэн 30 ширхэг, Самны касс 1 ширхэг, 00-н цаасны гэр 2 ширхэг, оо сойзны касс, Бүтээлийн хавтас 40 ширхэг зэргийг хаягдал өөдөс даавуу зэргийг ашиглан оёж хийсэн.

Ажлын байрны сургалтыг 1 удаа зохион явуулж 21 багш ажилтан хамрагдсан байна. Бэлтгэл бүлгийн ёс заншлын буланд олон үндэстний дээл хувцас малгай гутал зэргүүдийг хийж тохижууллаа.

Тайлан бичсэн ЗДТГ-ын ХЭЗ,ДХ

хариуцсан мэргэжилтэн

Б.Энхтуяа.